



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №10

НЭГ. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдолын мэдээлэл:

2022 оны 04-р сарын 04 нөөс 04-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй. (4-р хуудаснаас урьдчилан сэргийлэх зөвлөмжтэй танилцана уу)

ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний вирусн шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:

2022 оны 04-р сарын 04 нөөс 04-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Япон, Канада, Албани, Канад, АНУ, Норвеги, Исланд, Унгар, Болгар зэрэг улс орны газар нутагт нүүдлийн, тэжээвэр шувуудын дунд бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 1 ээс харна уу).

Шувууны томуугийн хүний өвчлөлийн (H5N1) мэдээлэл:

2022 оны 04-р сарын 04 нөөс 04-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

АНУ-н Хөдөө аж ахуйн мал эмнэлгийн лаборатори нь Мичиганы Уоштинэ мужид гэрийн тэжээвэр тоть шувуу шувууны томуу өвчнөөр өвчилсөн тухай мэдээлэв. Тэжээвэр шувуудыг гадаад орчинд гаргадаггүй. Гэрийн эзний гадуур хувцас, бохирдсон хоол тэжээл зэрэг орчны бохирдлоос халдвар авсан байх магадлалтай гэж үзсэн. <https://www.michigan.gov/mdard/about/media/pressreleases/2022/04/18/hpai-detected-in-washtenaw-county?fbclid=IwAR0h0WwUUDZcONGS7A-aoUDG8MojJ7BxDxli99s2hgVqmc-bEiSqT-wNASs>

Шувууны томуугийн хүний өвчлөлийн (H5N6) мэдээлэл:

2022 оны 04-р сарын 04 нөөс 04-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний H5N6 вирусн хүний өвчлөлийн нийт 2 тохиолдол бүртгэгдсэн.

БНХАУ-н Жянсү болон Сичуан мужийн Чжэньцзян, Дэян хотуудад 53, 56 настай эмэгтэй, эрэгтэй оршин суугч нарт өвчний шинж тэмдэг илэрч эмнэлэгт хандсан. Шинж тэмдэг илрэхээс өмнө тахиа шувууны худалдааны төвөөр орсон, мөн шувууны аж ахуйд ажиллаж байсан.

БНХАУ-ын Чунчин хотод 2021 оны 7-р сарын 09 нд H5N6 вирусн хүний өвчлөл бүртгэгдсэн ба нэг өдрийн дараа тухайн өвчтөний орсон шувууны аж ахуйд эпидемиологийн тандалт судалгаа хийж, шувуудаас арчдас цуглуулсан. Эдгээр сорьцнууд H5N6 дэд хэвшинжээр халдварласныг H5, N6 өвөрмөц праймер, проб ашиглан тодорхойлсон. Мөн 10 хоногтой, өвөрмөц эмгэгтөрөгчгүй тахианы хөврөлд вирус өсгөвөрөлсөн ба A/chicken/Chongqing/H1/2021(H5N6) (CK/CQ/H1) өсгөвөр гэж

тодорхойлсон. Гемагглютинин (НА) генийн филоген /удамзүйн/ шинжилгээгээр СК/СQ/Н1 болон A/Chongqing/02/2021 нь генетикийн хувьд хоорондоо ойр байсан ба Сичуан (2021), Хунань мужаас (2021) илрүүлсэн хүний H5N6 өсгөврийн адил 2.3.4.4b дэд бүлэгт хамаарагдсан. Эдгээр мужуудад бүртгэгдсэн хэвшинжийн НА ген нь 2020 оны сүүлээр Хятадад ирсэн зэрлэг шувуудын омгуудаас гаралтай байсан гэдгийг харуулж байна. Вакцины үр дүнг тахиа болон хулганд туршиж үзэхэд зарим шувуудад эсрэг бие тогтоогүй. <https://afludiary.blogspot.com/>

Шувууны томуугийн хүний өвчлөлийн (H7N9) мэдээлэл:

2022 оны 04-р сарын 04 нөөс 04-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний H7N9 вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

Шувууны томуугийн хүний өвчлөлийн (H9N2) мэдээлэл:

2022 оны 04-р сарын 04 нөөс 04-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний H9N2 вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

Шувууны томуугийн хүний өвчлөлийн (H7N4) мэдээлэл:

2022 оны 04-р сарын 04 нөөс 04-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

Шувууны томуугийн хүний өвчлөлийн (H5N8) мэдээлэл:

2022 оны 04-р сарын 04 нөөс 04-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

Шувууны томуугийн хүний өвчлөлийн (H10N3) мэдээлэл:

Мөн хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H10N3) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

2022 оны 04-р сарын 04 нөөс 04-р сарын 21 ний хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн хүний болон шувууны мэдээлэл:


(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусын хэв шинжээр тархалт

№	Мэдээлсэн өдөр	Өвчилж эхэлсэн өдөр	Дэд хэвшинж	Улс	Өвчилсөн шувуудын тоо	Өртсөн нийт хүн, шувуудын зүйл
1	3/28/2022	3/18/2022	H5N1	Албани	3	Борцгор хотон
2	3/29/2022	3/25/2022	H5N1	Бельги	193	Тахиа
3	3/29/2022	3/28/2022	H5N1	Герман	1	Харцага
4	4/11/2022	3/24/2022	H5N6	БНХАУ	1	53 настай эмэгтэй
5	4/11/2022	3/31/2022	H5N1	Япон	2	Үнэг, нохой элбэнх
6	4/11/2022	3/1/2022	H5N5	Норвеги	1	Цагаан сүүлт бүргэд
7	10/11/2021	10/11/2021	H5N1	Исланд	1	Цагаан сүүлт бүргэд
8	4/14/2022	4/13/2022	H5N1	Унгар	24	Тахиа

9	4/18/2022	4/13/2022	H5N1	АНУ	1	Тоть
10	4/20/2022	4/8/2022	H5	Болгар	1	Алаг шаазгай
11	4/20/2022	4/8/2022	H5	Болгар	93	Тахиа
12	4/20/2022	4/17/2022	H5N1	Унгар	1	Тахиа
13	4/20/2022	4/17/2022	H5N1	Канад	3	Галуу, бүргэд
14	4/21/2022	4/17/2022	H5	Исланд	2	Хэрээ, галуу
15	4/20/2022	3/31/2022	H5N6	БНХАУ	1	56 настай эрэгтэй
16	4/19/2022	4/17/2022	H5N1	АНУ	3	Шар шувуу
17	4/20/2022	4/19/2022	H5N1	Канад	10	Галуу
18	4/20/2022	4/19/2022	H5N1	АНУ	15	Тахиа

Эх сурвалж: www.poultrymed.com, Cidrap.umn.edu

(Зураг 1) 2022 оны 04-р сарын 04 нөөс 04-р сарын 21 ний хооронд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусын тохиолдлын тархалт /зургаар/



Шувууны томуугийн хөхтөн амьтдын өвчлөлийн мэдээлэл:

Шувууны томуугийн өндөр хоруу чанарт H5N1 хэвшинжээр нохой элбэнх *Nyctereutes procyonoides* (Gray, 1834) өвчилсөн тухай

Японы Саппоро хотод 2022 оны 04 сарын 10 нд нохой илбэнх H5N1 хэвшинжээр өвчилсөн тухай Япон улсын Байгаль Орчны Яам мэдээлсэн. Энэ нь тухайн улсад хөхтөн амьтан шувууны томуугаар өвчилсөн анхны тохиолдол болсон. Нохой элбэнх нь шувууны томуугаар хэд хэдэн хэрээ үхэж байсан бүсэд амьдарч байсан тул үхсэн шувуудаас халдвар авсан байх магадлалтай байна.

<http://outbreaknewstoday.com/japan-h5n1-avian-influenza-detected-in-raccoon-dog-tanuki-in-sapporo-hokkaido-39112/>

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Шувууны аж ахуй эрхлэгчид:

- Гадаад орчноос халдвар дамжин ирэх эрсдэлийг бууруулах зорилгоор зайлшгүй нэврэх ажилчид, техник хэрэгслийн жагсаалт гаргаж, нэвтрүүлэх
- Халдвар хамгааллын дэглэм мөрдөх буюу шувууны байранд орох болон гарахдаа гутлаа тогтмол цэвэрлэх, гараа тогтмол савандаж угаах, техник хэрэгслийн дугуйг халдваргүйжүүлэх
- Шувуудыг нүүдлийн шувууд болон төв суурин газрын бусад шувуудаас тусгаарлах
- Тэжээвэр шувууг худалдан авах, зарахдаа анхааралтай болгоомжтой хандах
- Шувууны гаралтай түүхий эдийг хагас боловсруулсан байдлаар хэрэглэхгүй байх

Шувууны аж ахуйд өвчний сэжигтэй, өвчилсөн шувууд бүртгэгдсэн үед:

- ЗӨСҮТ-н 70282853 дугаарт мэдээлэл өгөх
- Шувууны аж ахуйн орчинд нэвтрэх хүний болон техник хэрэгсэлийн хөдөлгөөнийг хязгаарлах, бүртгэл хөтлөх
- Төмөр тор, тоног төхөөрөмж, байрны бетон шал болон шалны хөндлөвч, хог зайлуулах суваг, шувууны суултуур, тэжээлийн сав, услуур зэрэгт халдваргүйжүүлэлтийг холбогдох зааврын дагуу хийх
- Өвчний сэжигтэй шувуудыг бусад шувуудаас тусгаарлах, мэрэгч амьтад орж гарах нүхийг битүүлэх
- Ханиадны шинж тэмдэг хүнд илрэвэл маск зүүж, эмнэлэгт хандах

Малчид, ард иргэдэд:

- Сэжигтэй /өвчилсөн, үхсэн/ зэрлэг шувуудад ойртохгүй байх
- Гол, нуурын эргээр техник хэрэгслээр явсан тохиолдолд гэрээс хол зогсоолд байршуулах, гуталны улыг арчиж гэртээ орох
- Шувууд олноор эндсэн нуурын усыг ахуйн хэрэгцээнд хэрэглэхгүй байх
- Шувууны аж ахуй, худалдааны төвөөр амны хаалттай байх